



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн дотоод хяналт шалгалтын дүн.

Аудитад хамаарах нэгжүүд: СЭЗХэлтэс, ДБХэлтэс, ХААХэлтэс

Огноо: 2022 оны 08 сар 10

АУДИТЫН ХУГАЦАА:

Эхлэх хугацаа 2022.07.20

Дуусах хугацаа 2022.08.10

Аудит хийх үндэслэл:

Дотоод аудиторын жилийн ажлын төлөвлөөгөөний дагуу гүйцэтгэх захирлаар батлуулсан хөтөлбөрийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилго:

Компанийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгнийн тайланд дотоод хяналт шалгалт хийж зөвлөмж гарган гүйцэтгэх удирдлагад танилцуулах, гарсан алдаа зөрчлийг арилгахад оршино.

Хамрах хүрээ:

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд дотоод хяналт шалгалтыг 6 чиглэлд хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө гаргасан. Үүнд:

- Борлуулалтын орлогын гүйцэтгэл
- Авлага, өглөг
- Мөнгөн хөрөнгийн гүйцэтгэл
- Цаг бүртгэл /Удирдлага, Алба, Хэлтэс/
- Аудитын зөвлөмжийн гүйцэтгэл
- Бараа материал

4. Аудитын арга зүй, стандартын мэдэгдэл:

Холбогдох ажилтантай ярилцах, тайлбар тодруулга авах, санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, анхан шатны баримт материалыг шалгах, тулган баталгаажуулах зэрэг арга зүй ашиглан цуглуулсан нотлох баримт судалгаанд баримтад дүн шинжилгээ хийж, нэгтгэн аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж өглөө.

Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт явуулах зохион байгуулах нийтлэг журам, ЭДЦС” ТӨХК-ийн дотоод хяналт шалгалт хийх журмын дагуу аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, ажлын баримтыг хавсаргав.

5. Аудитын шалгуур үзүүлэлтийн харьцаа

Аудит хийхэд дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
- “ЭДЦС” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж

Нөхцөл байдал:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар харилцах дансны үлдэгдэл **303.8** сая төгрөг байсан байна. Эхний хагас жилд **33,845.5** сая төгрөгийн цахилгаан, дулааны эрчим хүч борлуулсаны орлого орсон байна. Цалин, нүүрс, бэлтгэн нийлүүлэгч болон бусад

үйлдвэрлэлд шаардлагтай зардалд **33,783.3** сая төгрөгийн зарлага гаргаж **365.5** сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл тайлагнагдсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 8,809.1 сая төгрөгөөр нэмэгдэж үйлдвэрлэлээ дагаад зардал 10,519.3 сая төгрөгөөр өссөн байна.

Орлого нэмэгдэж байгаа гол үзүүлэлт нь цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлт нэмэгдсэнийг дагаад гол зардлууд болох нүүрсний зардал 3,357.2 сая төгрөгөөр, цалин 1,110.4 сая төгрөгөөр, сэлбэг, шатахуун, бэлтгэн нийлүүлэгчид төлөх зардал 6,529.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орлого			Зарлага		
Харилцах эхний үлдэгдэл	1,054.80	303.8			
Орлого	2021 он II улирал	2022 он II улирал	Зарлага	2021 он II улирал	2022 он II улирал
ЦЭХ-ны орлого	16,402.30	26,686.90	Нүүрс	7,663.20	11,020.40
ДЭХ-ны орлого	4,887.60	4,763.80	Цалин	4,725.90	5,836.30
Касс		6.6	Сэлбэг, гэрээт ажил, шатахуун	3,894.10	10,424.10
Нүүрс			НДШ	1,849.20	1,948.00
Харилцах	3,570.00	2,211.50	НӨАТ	450	236
Зам арчлалт, таталт тавилт	69.9	19.6	ХАОАТ	450.6	645.6
ХЧТА тэтгэмж	24.7	27.1	Төмөр зам	22	841.5
Банкны залруулга	9.1	85.9	Хоол суутгал	185.1	156.1
Банкны хүүгийн орлого	2.6		Холбооны суутгал	116.5	123.1
Техникийн нөхцөл			ҮХХТатвар	114.6	115.7
Бусад	70.2	44.1	ҮЭ татвар	51.3	37
			Касс	-	-
			Харилцах	3,550.00	2,211.50
			Бусад	191.9	188.5
Дүн	25,036.40	33,845.50		23,264.50	33,783.80
Эцсийн үлдэгдэл					365.5

Санхүүгийн шинжилгээг хийж тайлан бэлтгэх явцад орлогоор хүлээн зөвшөөрөгдөхгүй 2,331.1 сая төгрөг, зарлагаар хүлээн зөвшөөрөгдөхгүй 2,211.5 сая төгрөгийг нэмж тайлагнасан байна. Энэ хэрэглэгч буруу мэдээллээр хангагдаж байгууллагын талаар ташаа ойлголт авах эрсдэлтэй байна.

Эхний хагас жилийн турш кассар 7.1 сая төгрөгийн гүйлгээ хийж бэлэн мөнгөний урсгалыг бууруулсан байна. /Кассын зарлага 13.7 сая төгрөгнөөс харилцах дансанд тушаасан 6.6 сая төгрөг хасагдаж кассын цэвэр зарлага 7.1 сая төгрөг/

2022 оны эхний хагас жилд 18,100.4 сая төгрөгийн түлш, түүхий эд, сэлбэг, бараа материалыг орлогод авч, 16,317.6 сая төгрөгийн түлш, түүхий эд, сэлбэг, бараа материалыг зарлагадан нийт агуулахын үлдэгдэл 4,184.9 сая төгрөг болж оны эхнээс 1,782.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Агуулахын үлдэгдэлд өсхөд нүүрс, сэлбэг материал, химийн материал гэсэн голлох материалууд эзэлж байна.


- Үүнд: Нүүрс 368.0 сая төгрөгөөр
- Мазутын 181.5 сая төгрөгөөр
- Үндсэн сэлбэг хэрэгсэл 441.4 сая төгрөгөөр
- Багаж хэрэгсэл 4.6 сая төгрөгөөр
- Шатахуун ба шингэн түлш 77.6 сая төгрөгөөр
- Тос тосолгооны материал 112.9 сая төгрөгөөр
- Тээврийн хэрэгслийн сэлбэг 0.5 сая төгрөгөөр
- Химийн материал 420.5 сая төгрөгөөр
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны материал 179.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хангамжийн материалын үлдэгдэл 4.0 сая төгрөгөөр буурсан байна. Өргөтгөлийн ажил дуусч бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны худалдан авалтын захиалга нэмэгдэж бэлтгэн нийлүүлэгчдээс жилийн хэмжээний бараа материалууд нийлүүлэгдэж оны эхний үлдэгдлээс өссөн дүнтэй харагдаж байна.

Нийт авлагын 90.4%-ийг цахилгаан эрчим хүчний, 9.6%-ийг дулааны эрчим хүчний болон бусад авлага эзэлж байна.

Эхний хагас жилийн байдлаар 1,245.8 сая төгрөг авлагын үлдэгдэл бүртгэгдэж оны эхнээс 4,463.3 сая төгрөгөөр, зорилтоос 5,864.8 сая төгрөгөөр буурсан.

Авлагыг оны эхний үлдэгдэлтэй харьцуулж үзвэл Цахилгаан эрчим хүчний авлага 4,290.9 сая төгрөгөөр, ДЭХүчний авлага 172.4 сая төгрөгөөр буурсан байна. Авлага буурч байгаа нь байгууллагын мөнгөний дутагдалд орох эрсдэлийг багасгах эерэг үзүүлэлт гарч байна.



Нийт өр, төлбөр эхний хагас жилийн байдлаар 8,784.7 сая төгрөг байна. Энэ нь эхнээс 1,965.0 сая төгрөгөөр өссөн байна. Жилийн зорилтот түвшингээс 154,468.4 сая төгрөгөөр буурсан байна.

- Дансны өглөг Шарын гол 1,437.8 сая төгрөг
- Нутгийн буян ХХК 966.3 сая төгрөг
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 327.9 сая төгрөг
- ЯВМ ХХК 285.4 сая төгрөг
- Грийн химистри ХХК 245.0 сая төгрөг
- Интер стандарт нефть ХХК 236.8 сая төгрөг
- Содмонгол групп ХХК 214.8 сая төгрөг тус тус байна
- “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-с 240.5 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэгдсэн байна.

Байгууллагын хэмжээнд цаг бүртгэлийг 2 хэлбэрээр гүйцэтгэж байна. Үндсэн цаг бүртгэл нь царай таних системийг ашиглан ABLE программд бүртгэж байна. Туслах программ нь ажлын цагаар ажлын байрнаас гарах ажилчдын цагийг ажлын үнэмлэхний тусламжтай шалган нэвтрүүлэх байранд бүртгэж байна. Ажлын цаг бүртгүүлдэггүй ажилчин байхгүй байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Орхон аймаг дахь төрийн аудитын газар баталгаажуулалт хийсэн бөгөөд төлбөрийн акт 4, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага 1, зөвлөмж 7-г өгсөн байна.

Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 06-р сарын 08-ны өдөрийн 02/549 тоот албан бичгээр ЭХЯаманд, 05/550 тоот албан бичгээр Орхон аймаг лахь Төрийн аудитын газарт, 02/551 тоот албан бичгээр ҮАГазрын санхүүгийн аудитын газарт тус тус хүргүүлсэн байна.

4 төрлийн төлбөрийн актыг буруутай хүмүүсээр төлүүлсэн бөгөөд байгууллагаас төлбөрийн актыг барагдуулахад ямар нэгэн мөнгө зарцуулаагүй байна.

Албан шаардлага, зөвлөмжүүд нь он дуустал болон цаашид давтан гаргахгүй байхаар өгөгдсөн байна.

Эхний хагас жилийн байдлаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжүүдэд харшлах нийтийг хамарсан шинжтэй шагнал урамшуулал олгогдоогүй байна.

Хагас жилийн санхүүгийн тайланд хийх дотоод хяналтад бараа материал үзэх ажил тусгагдсан байсан тул хагас жилийн тооллогын комиссын бүрэлдэхүүнд орж бараа материалын тооллогыг гүйцэтгэсэн. Эхний хагас жилд 18,100.4 сая төгрөгийн түлш, түүхий эд, сэлбэг, бараа материалыг орлогод авсан байна. Үүнээс 16,317.6 сая төгрөгийн түлш, түүхий эд, сэлбэг, бараа материалын зардал гарч 4,184.9 сая төгрөгийн түлш, түүхий эд, сэлбэг, бараа материалын үлдэгдэлтэй байна.

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Түлш: Нүүрс	972.2	15,054.8	14,686.8	1,340.2
2	Түлш: Мазут	124.5	236.8	55.3	306.0
3	Үндсэн сэлбэг хэрэгсэл	982.1	915.6	474.2	1,423.6
4	Багаж хэрэгсэл	10.3	22.8	18.2	14.9
5	Хангамжийн материал	34.1	96.6	100.6	30.1
6	Шатахуун ба шингэн түлш	48.8	470.8	393.3	126.3
7	Тосолгооны материал	62.1	288.5	175.6	175.0
8	Тээврийн хэрэгслийн сэлбэг	42.0	90.7	90.2	42.4
9	Химийн материал	41.3	643.7	223.2	461.7
10	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	43.7	280.0	100.3	223.5
11	Бусад бараа материал	41.1	-	-	41.1
ДҮН		2,402.2	18,100.4	16,317.6	4,184.9

Агуулахын үлдэгдэлд шинжилгээ хийж үзвэл 9 нэр төрөл дээр 1,786.7 сая төгрөгөөр өсч, 1 нэр төрөл дээр 4.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Үлдэгдэл өсч гарах болсон нь 2022 оны тоног төхөөрөмж, бараа материал, химийн материал, тос тосолгооны материалын худалдан авалт эхэлж графикийн дагуу их засварууд хийгдэж байгаатай холбоотой байна. Компанийн гол зардалууд болох түүхий эд материал (нүүрс, мазут)-ын үлдэгдэл нь нийт үлдэгдлийн 39.3%-ийг эзэлж байна.

Оны эхэнд 18.9мян.тн нүүрсний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд 297.5 мян.тн нүүрс орлогод авсан байна. Гүйцэтгэлээр 287.0мян.тн нүүрс, хэвийн болон тээврийн хорогдол 3.0мян.тн нүүрс тус тус зарцуулагдаж үлдэгдэл 26.2мян.тн байна. Энэ нь төлөвлөсөн ачааллаар 24 хоногийн нөөцтэй байна.

2022 оны 05-р сарын 31-ны өдрөөр дизель түлш 66,822.78л-ийн үлдэгдэлтэй байна. 2020.06.20-ны өдөр тооллого хийхэд 1-р бак 48,216.6л, 2-р бак 6,697.4л нийт 54,914л дизель түлш тоологдсон. 6-р сарын 20 хүртлэх шаардах хуудсаар 10,780л дизель түлшний зарлага гарсан байна.

Тооллогоор 1,129л дизель түлш зөрсөн.

2022.05.31-ны өдрөөр тасалбар болсон 35 нэр төрлийн шатах тослох материалд тооллого хийхэд 6 нэр төрлийн сэлбэг материал дутсан.

8 нэр төрлийн материал дансны үлдэгдэлээс илүүдсэн байна. Цехүүд шаардах хуудас бичин авсан боловч складанд түр хадгалуулсан материалууд байх үндэслэлтэй боловч нярвуудын ажлыг хүлээлцэх явц хангалтгүй хийгдсэнтэй холбоотой байна.

Шинээр ажил авч буй няравт албан ёсоор хүлээлгэж өгөөгүй байгаа нь нягтлан бодогч хангалтгүй ажиллаж байгааг харуулж байна.

Дутсан материал бүрийг хүснэгтээр харуулав:

№	Код	Материалын нэр	Хэмжих нэгж	Эцсийн үлдэгдэл	Тоолсон	зөрүү	Зарлага дутуу гаргасан сарууд		Тайлбар
							4-р сар	5-р сар	
1	ж171007	д/түлш ШТС	Литр	66823	65694	1129			2022.06.20-ны өдөр тоолсон. 1-р бак 48216.6л, 2-р бак 6697.4л байсан. 2022.06.01-2022.06.20-ны хооронд 10780л дизель түлш шаардах хуудсаар олгогдсон байна. 1129л дизель түлш тооллогоор дутсан
2	ж171221	Мобайл делвак МХ 10W30 6л	Литр	468	634	8	52		2022.03.31-нд Буяндалай 16л авсан 2022.04.25-нд Отгонжаргал 36л авсан 2022.06.07-нд Отгонжаргал жолооч 18л авсан 2022.06.07-нд Эркебек жолооч 24л авсан 2022.06.02-нд Сансаргэрэл 6л авсан 2022.06.13-нд Буяндалай 8л авсан 2022.06.07-нд Отгонжаргал жолооч 18л авсан 8л зарлагын баримт байхгүй. Тооллогоор дутсан
	Ж171233	С/Дизель 10/30	Литр	174					
3	Ж171204	Дизель масло	Литр	768	3208	78	16	28	2022.04.13-нд Түвшинтөгс 16л авсан 2022.05.01, 09, 16-нд 12л авсан 2022.05.03, 04, 13, 16-нд 16л Насанбат авсан 78л зарлагын баримт байхгүй. Тооллогоор дутсан
	ж171310	Дизель масло М10 дм 4л	Литр	2518					
4	ж171205	Тормозны шингэн дот-4 0,455л	Литр	88	162	9		2	2022.05.26-нд Сансаргэрэл 0.910л авсан 2022.05.24-нд Саяннямбуу 0.910л авсан 2022.06.14-нд Гантөмөр 0.455л авсан 2022.06.17-нд Түвшинтөгс 1.82л авсан 9л зарлагын баримт байхгүй. Тооллогоор дутсан
	Ж171236	Росdot-4 г/шингэн	Литр	83					
5	Ж171219	Масло АС-8 /М-8В/	Литр	247	244	3			3л зарлагын баримт байхгүй. Тооллогоор дутсан
6	ж171231	литол-24	Кг	444	414	30			30л зарлагын баримт байхгүй. Тооллогоор дутсан

Илүү тоологдсон материалын жагсаалт:

№	Код	Материалын нэр	Хэмжих нэгж	Эцсийн үлдэгдэл	Тоолсон	зөрүү	Тайлбар
1	Ж171222	Турбины масло ТП-22/Сүүлийн/	Литр	7380	12505	-4920	Шаардах үзэх
	Ж171212	Турбины масло ТП-22	Литр	205			
2	Ж171225	И-50 ТОС	Литр	800	9430	-1070	2022.06.15-нд Зуух 205л авсан
	Ж171232	И-50 масло	Литр	7560			
3	Ж171230	Трансформаторын масло ТБЦД	Литр	1909	2000	-66	Тайлбар байхгүй. Нягтлан бодогч мэдэхгүй
	Ж171211	Трансформаторын тос	Литр	25			
4	Ж171203	Смазка /товуд/1-13 21кг	Кг	588	882	-3	Тайлбар байхгүй. Нягтлан бодогч мэдэхгүй
	ж171289	Смазка 1-13	Кг	291			
5	ж171285	Супер тап 5w30	Литр	82	86	-4	Тайлбар байхгүй. Нягтлан бодогч мэдэхгүй
6	ж171250	и-20А	Кг	2676	3000	-324	2022.06.15-нд ТДЦ 80л авсан Тайлбар байхгүй. Нягтлан бодогч мэдэхгүй
7	Ж171208	Салидол	Кг	1186	1239	-53	Тайлбар байхгүй. Нягтлан бодогч мэдэхгүй
8	Ж171217	Кали К-19 масло	Литр	388	410	-22	Тайлбар байхгүй. Нягтлан бодогч мэдэхгүй

Материалын зардлын хувьд дараах алдаанууд гарсан байна.

Үүнд:

1. 2022 оны 04, 05-р сарын шатах тослох материалын зарлагыг дутуу бүртгэж санхүүгийн тайланг худлаа тайлагнасан.
2. 9 нэр төрлийн шатах тослох материалд 18 өөр нэр өгч бүртгэлд тусгасан.
3. Хэмжих нэгжийг зөрүүлж орлого авсан. /0.455-гр савалгаатай Тормозны шингэн дот-4-г кг, ширхэг гэсэн 2 нэгжээр бүртгэж зарлага гаргасан./
4. Нягтлан бодогч бүртгэлээр тавих хяналтыг хийгээгүй. Ажлын хариуцлага алдсан.
5. Няруудын ажлыг сайн хүлээлцүүлээгүй.
6. Нягтлан бодогч Илүү тоологдож буй материалуудыг тайлбарлаж чадаагүй.
7. Шатах тослох материал хадгалж буй склад эмх цэгц маш муу байна.
8. Худалдан авалтаар бууж байгаа шатах тослох материалыг агуулах нөхцлөөр буулгах гэрээний заалт хэрэгжихгүй байна. Масло станцад буусан шатах тослох материалыг эд хариуцагч ганцаараа хүлээн авсан.

Дүгнэлт:

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан хуулийн хугацаанд бүрэн тайлагнагдсан боловч материалын нягтлан бодогчийн ажил хангалтгүй байна.

Зөвлөмж:

1. Санхүүгийн тайланд шинжилгээ хийж материал бэлдэхдээ хүлээн зөвшөөрөгдөхгүй орлого зарлагын гүйлгээг хасч бэлтгэж байх. /Ж: Нэр данс зөрүүтэй буцсан гүйлгээ, кассаас харилцахруу татсан мөнгөн гүйлгээ гэх мэт/
2. Худалдан авалтаар бууж байгаа материалуудыг агуулах нөхцлөөр буулгах гэрээний заалтыг хэрэгжүүлэх.
3. 2022 оны 04, 05-р саруудад дутуу гаргасан зардлыг залруулах

4. Шатах тослох материалыг шаардах хуудсаар олгодог болгох.
5. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж чадахгүй байгаа нягтлан бодогчид хариуцлага тооцох.
6. Шинээр ажил авч ажиллаж буй няравт үүрэг даалгавар өгч складын эмх цэгц, бүртгэл хөтлөлтийг сайжруулах.
7. Дутсан хөрөнгийг төлүүлэх.

Танилцсан:

Гүйцэтгэх захирал

Б.Бат-Эрдэнэ

Хянасан:

ДХХдарга

М.Галхүү

Тайлан бичсэн:

Дотоод аудитор

С.Үнэнхүү